# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ ГАРГАХ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахгүй байгаагаас хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийг хууль журамд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангаж төлөвлөөгүй зөрчил давтагдсаар байна.**

**АУДИТЫН КОД: ХӨА-2023/12-21-НА-НА**


Дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Давааням
Утас:92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn
Ахлах аудитор З.Даваадорж
Утас: 89100230 Цахим хаяг: davaadorjz@audit.gov.mn
Аудитор С.Гансүх
Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn
Аудитор Л.Мандахнаран
Утас: 92118277 Цахим хаяг: mandakhnaranl@audit.gov.mn
Аудитор Г.Ичинхорлоо
Утас: 88688168 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn
Аудитор Н.Гүрбазар
Утас: 921188084 Цахим хаяг: Gurbazarn@audit.gov.mn
Аудитор Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn
Аудитор Л.Мөнх-Оргил
Утас: 99039344 Цахим хаяг: munkh-orgill@audit.gov.mn


Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.khuvsgul.audit.mn

**Хөвсгөл аймаг**

**2023 он**

## АГУУЛГА


| Агуулга | Хуудасны дугаар |
|---|---|
| Товчилсон үгийн тайлбар | 2 |
| Аудитын тайлан баталгаажуулах тушаал | 3 |
| Аудит хийх үндэслэл, бүрэн эрх | 4 |
| Аудитын зорилт | 4 |
| Аудитын хамарсан хүрээ | 4 |
| Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| Аудитын бүрэлдэхүүн, хугацаа | 5 |
| Аудитын хязгаарлалт | 5 |
| Үндсэн мэдээлэл | 6-7 |
| **БҮЛЭГ 1. Хөвсгөл аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 17, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй 6 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгасан байна.** | 7 |
| 1.1. Орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-аар хэрэгжих 23 төсөл, арга хэмжээ нь Хөвсгөл аймгийн хөгжлийн бодлогын зарим баримт бичигтэй нийцэхгүй байна. | 7 |
| **БҮЛЭГ 2. Орон нутгийн 2024 оны төсвийн төслийг хянаж орлого нэмэгдүүлэх 1,020.7 сая төгрөгийн, зардал бууруулах 439.8 сая төгрөгийн санал хүргүүлж, нийт 629.6 сая төгрөгийг аудитын хугацаанд хүлээн зөвшөөрүүлсэн.** | 8 |
| 2.1. Сангийн яамны баталсан суурь орлогыг 6,378.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн ба аудитын хугацаанд орон нутгийн орлогыг 1,020.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал хүргүүлсэн. | 8-10 |
| 2.2. Төсвийн төслийг нэгтгэн боловсруулахдаа ТЕЗ-ийн хяналтад байгаа байгууллагуудын төсвийн төслийн зардлыг ангиллаар нь гаргуулаагүй, бодит тооцоо судалгаанд үндэслэж, хяналт тавьж чадахгүй байгааг харуулж байна. | 10-14 |
| **БҮЛЭГ 3: Хөвсгөл аймгийн 2024 оны төсвийн төсөлд тусгасан хөрөнгө оруулалтын ихэнх төсөл арга хэмжээнүүд нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.** | 14 |
| 3.1 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүд нь хуульд заасан шалгуурыг бүрэн хангахгүй байна. | 14-16 |
| 3.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 41.6 хувьтай байна. | 17-18 |
| Аудитын дүгнэлт | 19 |
| Аудитын зөвлөмж | 20 |
| Зөрчлийн нэгтгэл | 21-22 |
| Хавсралтууд | 23-29 |
| Байгууллагын санал | 30-32 |

## Товчилсон үгийн тайлбар

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АИТХ | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БОХНСАХЗ | Байгаль Хамгаалах Нөхөн Сэргээх Арга Хэмжээний Зардал |
| ЗДТГ | Засаг Даргын Тамгын Газар |
| ЗДҮАХ | Засаг Даргын Үйл Ажиллагааны Хөтөлбөр |
| БОАЖГ | Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар |
| ЗГ | Засгийн Газар |
| МУ | Монгол Улс |
| УИХ | Улсын Их Хурал |
| ОНХС | Орон Нутгийн Хөгжлийн Сан |
| ОНХО | Орон Нутгийн Хөрөнгө оруулалт |
| ХАА | Худалдан Авах Ажиллагаа |

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ**
**АУДИТОРЫН ТУШААЛ**

2023 оны 11 сарын 27 өдөр Дугаар А/36 Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дахь заалт, 2023 оны А/102 дугаар тушаалаар баталсан "Эрх шилжүүлэх тухай" тушаалын 4 дүгээр хавсралын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөвсгөл аймгийн орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах" гүйцэтгэлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга(Г.Мөнгөнхуяг)-т, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга (П.Лхагважав)-д тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор (Б.Давааням)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер (Б.Тэгшдэлгэр)-т даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

| | |
|---|---|
| **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх** | Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1, Монгол улсын ерөнхий аудиторын 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-ын дагуу гүйцэтгэлээ. |
| **Аудитын зорилт** | Хөвсгөл аймгийн Засаг даргаас аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гарган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хуралд хүргүүлж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдлээ.<br>Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:<br>1. Орон нутгийн төсвийн төсөл нь аймаг орон нутгийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт нийцсэн эсэх<br>2. Орон нутгийн 2024 оны төсвийн төслийн зардлыг үр дүнд суурилсан арга аргачлалаар, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлэн хэмнэлттэй үр ашигтай байхаар бодитой тооцож төлөвлөсөн эсэх<br>3. Орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх жагсаалтад орсон төсөл арга хэмжээнүүд нь хууль журамд заасан шаардлагыг хангасан эсэх. |
| **Аудитын хамарсан хүрээ** | Хөвсгөл аймгийн орон нутгийн 2024 оны төсвийн төлөвлөлт, орон нутгийн орлогын тооцоо, төсвийн зарлагын тооцоо, Аймгийн Засаг даргаас аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн төсвийн төсөл, хөрөнгө оруулалт, ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээтэй холбогдох баримт материалуудыг хамруулав.<br>Орон нутгийн төсөв боловсруулахтай холбоотой АИТХ-ын дарга, ажлын алба, Аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, мэдээлэл, холбогдох баримт материал гаргуулах, авах зэргээр хамтран ажиллаа. |
| **Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт** | Аудитыг АДБОУС нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчид тулгуурлан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол улсын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-д заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад тулгуурлан судалгаа, шинжилгээ, харьцуулалт, баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглаж аудитыг гүйцэтгэсэн.<br>Аймгийн орон нутгийн 2024 оны төсвийн төлөвлөлттэй холбоотой эрх зүйн актыг судлах, АИТХ-ын ажлын алба, Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн |

| | |
|---|---|
| | аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн үр дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.<br>Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.<br>Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасан шаардлага, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 244 дугаар тушаалаар батлсан “ Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ыг гол шалгуур болголоо. |
| **Аудитын бүрэлдэхүүн, хугацаа** | Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Давааням, З.Даваадорж, аудитор С.Гансүх, Л.Мандахнаран, Г.Ичинхорлоо, Н.Гүрбазар, Ган.Ичинхорлоо, Л.Мөнх-Оргил нар төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.<br>Аудитын урьдчилсан судалгаа, төлөвлөлтийн үе шатны ажлыг 2023 оны 10 дугээр сарын 15-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 03-ний өдрийн дотор гүйцэтгэж, аудитын төлөвлөгөөг Тэргүүлэх аудитораар батлуулсан.<br>Аудитын талбарын ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 25-ны дотор гүйцэтгэх бөгөөд аудиторууд талбарын ажлын дэд тайланг зэрэгцүүлэн бичиж, үе шатны чанарын хяналтыг хийлгэсэн.<br>Аудитын тайланг 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга холбогдох албан тушаалтанд хүргүүлнэ.<br>Аудитын тайланд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжөөс гадна холбогдох байгууллагын саналыг тусгалаа. |
| **Аудитын хязгаарлалт** | 2023 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр аймгийн ИТХ-аар төсөв батлуулах тогтоолын төсөл, зардлын холбогдох танилцуулгыг ирүүлсэн, төсвийн зарлагын тооцооллыг ирүүлээгүй зэрэг нь хуулийн хугацаанд санал дүгнэлт гаргах нөхцөл боломжийг хязгаарласан. |

**Үндсэн мэдээлэл**

Монгол улсын Засгийн газраас 2024 оны төсвийн хүрээнд бодлогын 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.Үүнд:

1. Шинэ сэргэлтийн бодлого- Хот, хөдөөгийн сэргэлт
2. Төрийн албан хаагчдын цалин хөлсийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлнэ
3. Ахмадын тэтгэврийг нэмэгдүүлж, эдийн засгийн баталгааг хангана
4. Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлнэ
5. Багш ажилчдын нийгмийн баталгааг сайжруулах болон багш бэлтгэхтэй холбоотой бодлогын арга хэмжээний зардлыг 2024 оны төсөвт бүрэн тусгах
6. Уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшнийг дээшлүүлэх, нэмүү өртөг шингэсэн уул уурхайн бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэхэд татварын бодлогоор дэмжинэ
7. Хөрөнгө оруулалтын орчныг сайжруулж, үнэт цаасны зах зээлийг татварын бодлогоор дэмжинэ.
8. Малчдын орлогын, НӨАТ, малын тоо толгойн албан татвар тайлан боловсруулах, тушаал үүргээс чөлөөлөх, НӨАТ суутган төлөгч болох шаардлагагүй болгох замаар татварын орчныг хялбаршуулан малын гаралтай түүхий эдийн бүртгэлийг сайжруулж, боловсруулах үйлдвэрүүдийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэж дэмжлэг үзүүлнэ.
9. Хөгжилд чиглэсэн хөрөнгө оруулалт
10. Байгалийн баялгийн өгөөжийг орон нутгийн хөгжилд чиглүүлнэ.

Монгол улсын Их Хурлаас 2024 оны төсвийг 2023.11.10-ны өдөр баталж, Засгийн газраас 2024 онд баримталсан төсвийн бодлого, чиглэлийг орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд тусган боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулах, баталсан төсвийг хэрэгжүүлэхэд дараах зүйлсийг чиглэл болгон ирүүлсэн байна. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах
2. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулах
3. Төсвийн зарлагыг хэмнэлттэй үр ашигтай байх зарчмыг баримтлан, хууль, журмын хүрээнд төлөвлөн, хэрэгжүүлэх
4. Орон нутгийн үр дүнгийн үзүүлэлтийг сайжруулах /үр дүн,гүйцэтгэлд суурилсан төсөвлөлтийг орон нутгийн түвшинд нэвтрүүлэх/
5. Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг бууруулахгүй байх
6. Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зардал, арга хэмжээг санхүүжүүлж, дэмжих

Хөвсгөл аймгийн 2024 оны төсвийн төсөл 2025-2026 оны төсвийн төсөөллийг нэгтгэн боловсруулж аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн 1/1260 дугаартай албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн орон нутгийн 2024 оны төсвийн төслийг боловсруулахдаа Сангийн яамны 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, сангийн яамнаас ирүүлсэн төсвийн хязгаар, төсвийн удирдамж, Төсвийн тухай хууль, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам зэргийг баримтлан ажилласан байна.

Аймгийн орон нутгийн 2024 оны төсвийн төслийг хянан үзэж дүгнэлт гаргахад Төсвийн тухай хуульд заасан зарчим, шаардлага, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангган төсөвлөсөн эсэхийг онцгойлон авч үзлээ.

Сангийн яамнаас Хөвсгөл аймгийн орон нутгийн 2024 оны төсвийн суурь орлогын хязгаарыг 28,400.6 сая төгрөг, зардлыг 49,243.0 сая төгрөгөөр тус тус тогтоосон байна.

УИХ-аас баталсан Хөвсгөл аймгийн орон нутгийн 2024 оны төсвийн орлого, зардлыг 6,378.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, орлогыг 93,651.9 сая төгрөг, зардлыг 93,651.9 сая төгрөг болгосноор төсвийн тэнцэл хангагдсан байна.

Хөвсгөл аймгийн 2024 оны төсвийн төслийг Сангийн яамны хязгаартай харьцуулбал дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт: №-1. Төсвийн төслийн суурь орлого* */сая.төг/*

| № | Орлогын зүйл | Сангийн яамны хязгаар | Сангийн яамнаас хянасан | 2024 оны төсвийн төсөл |
|---|---|---|---|---|
| 1 | Татварын орлого | 27,052.5 | 23,026.7 | 28,742.3 |
| 2 | Татварын бус орлого | 1,328.0 | 1,676.2 | 2,308.5 |
| 3 | Хөрөнгийн орлого | 20.1 | - | 30.1 |
| | **Дүн** | **28,400.6** | **24,702.9** | **31,080.9** |

Суурь орлогыг Сангийн яамны хязгаараас 2,680.3 сая төгрөгөөр, Сангийн яамны хянасан орлогоос 6,378.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

*Хүснэгт №-2 Төсвийн төслийн суурь зардал* */сая.төг/*

| № | Зардлын зүйл | Сангийн яамны хязгаар | Сангийн яамнаас хянасан | 2024 оны төсвийн төсөл |
|---|---|---|---|---|
| 1 | Урсгал зардал | 47,314.2 | 55,035.6 | 68,612.8 |
| 2 | Хөрөнгийн зардал | 1,928.9 | 1,928.9 | 5,456.6 |
| | **Нийт зардал** | **49,243.1** | **56,964.5** | **74,069.4** |

Суурь зардлыг Сангийн яамны хязгаараас 24,826.3 сая төгрөгөөр, Сангийн яамны хянасан зарлагаас 17,104.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

## *БҮЛЭГ* 1. Хөвсгөл аймгийн 2024 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 17, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй 6 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгасан байна.

### 1.1 Орон нутгийн хөрөнгө оруулалт, ОНХС-аар хэрэгжих 23 төсөл, арга хэмжээ нь Хөвсгөл аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцэхгүй байна.

Хөвсгөл аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичиг “Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл”-ийг аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр тогтоолоор 8 зорилго 27 зорилт 146 дэд зорилттой, аймгийн ЗД-ын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2021 оны 02 дугаар тогтоолоор 6 зорилго 38 зорилт 243 дэд зорилттой тус тус батласан байна.

Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засаг даргын 2022 оны А/41 дүгээр захирамжаар 475 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Монгол улсын Төсвийн тухай хуулийн $29^1$ дүгээр зүйлийн $29^1$.2.5-д зааснаар төсвийн хөрөнгө оруулалт нь хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх шаардлагатай.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийх төсөл, арга хэмжээнүүдийг хөгжлийн бодлогын дунд болон богино хугацааны бодлогын зорилтуудтай уялдсан эсэхийг тулган хянахад дунд хугацааны буюу Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд 12,857.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 68 төсөл, арга хэмжээнд 7,940.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор төлөвлөсөн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 68 төсөл арга хэмжээнээс 1,661.1 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг /хавсралт №2/ Хөвсгөл аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгаагүй байна. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.4-т заасан *“орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх”* гэсэн шаардлагыг хангахгүй байна. Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан

дээрх 14 төсөл арга хэмжээг яагаад төлөвлөлтөд оруулаагүй талаар ямар нэгэн тайлбар тодруулга байхгүй нь аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөө биелэхгүй байх эрсдэлийг дагуулж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээнүүд нь аймгийн орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцээгүй байна.  Үүнд:

*Хүснэгт №-3* *\/сая.төг/*

| № | Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй арга хэмжээ | Төсөвт өртөг /сая.төг/ |
|---|---|---|
| 1 | Цэцэрлэгийн тоглоомын талбайн тохижилтыг нэмэгдүүлэх /Мөрөн сум 15 цэцэрлэгт/ | 80.0 |
| 2 | Мөрөн сумын "Хийморийн овооны тохижилтын ажил эхлүүлэх" /Мөрөн сум/ | 301.2 |
| 3 | Техник хэрэгсэл /Цагдаагийн газар/ | 50.0 |
| 4 | Угтах үдэх хаалга орчмын тохижилтын ажил /Мөрөн сум/ | 270.3 |
| 5 | Цэвэр усны ухаалаг тоолуур худалдан авах /Ус суваг/ | 90.0 |
| 6 | Бохирын шугам худалдан авах /Эрхэс ХҮТ-ын хажуугийнх/ | 50.0 |
| **Нийт дүн** | | **841.5** |

*Хөвсгөл аймгийн 2024 оны төсвийн төсөлд тусгасан хөрөнгө оруулалтын арга хэмжээнүүдээс 23 төсөл арга хэмжээ нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаагаас харахад орон нутгийн төсөв нь аймгийн хөгжлийн бодлогыг дэмжихгүй байна.*

## *БҮЛЭГ* 2. Орон нутгийн 2024 оны төсвийн төслийг хянаж орлого нэмэгдүүлэх 1,020.7 сая төгрөгийн, зардал бууруулах 439.8 сая төгрөгийн санал хүргүүлж, нийт 629.6 сая төгрөгийг аудитын хугацаанд хүлээн зөвшөөрүүлсэн.

### 2.1. *Сангийн яамны баталсан суурь орлогыг 6,378.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн ба аудитын хугацаанд орон нутгийн орлогыг 1,020.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал хүргүүлсэн.*

Хөвсгөл аймгийн 2024 оны төсвийн орлогын төлөвлөгөөг нийт 93,651.9 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн байна. Орлогыг эх үүсвэрээр нь авч үзвэл улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээс 43,617.0 сая төгрөгийг, орон нутгийн суурь орлогоос 31,080.9  сая төгрөг, дансны үлдэгдлээс 2,774.7 сая төгрөг, төсвийн байгууллагын өөрийн орлогоос 138.0 сая төгрөг, ОНХНС-аас 15,990.5 сая төгрөгийг тус тус бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Санхүүгийн дэмжлэг 43,617.0 сая төгрөгөөр батлагдаж ирсэн нь 2023 оны тодотгосон төлөвлөгөөнөөс 16,841.5 сая төгрөг буюу 38.5 хувиар, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр 15,990.5 сая төгрөгөөр батлагдаж ирсэн нь 2023 оны төлөвлөгөөнөөс 1,587.2 сая төгрөг буюу 11 хувиар өссөн үзүүлэлтэй байна.

Орон нутгийн суурь орлогыг Сангийн яамны хянасан дүнгээс 6,378.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт 31,080.9 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн байна.

**Суурь төсвийн орлогын төслийг хүснэгтээр харуулбал:**

*Хүснэгт №-4* *сая.төг*

| Д/д | Орлогын төрөл | 2023 оны | 2024 оны | | |
|---|---|---|---|---|---|
| | | ХБГ | СЯ хянасан суурь орлого | Орлогын төлөвлөгөөний төсөл | Зөрүү /2024 он батлах-СЯ хянасан/ |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **1** | **НИЙТ ОРЛОГО** | **27,663.5** | **24,702.9** | **31,080.9** | **6,378.0** |
| **2** | **УРСГАЛ ОРЛОГО** | **27,508.2** | **24,702.9** | **31,050.8** | **6,327.9** |
| **3** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **25,189.1** | **23,077.6** | **28,142.2** | **5,064.6** |
| **4** | **Орлогын албан татвар** | **16,178.7** | **16,553.0** | **19,753.0** | **3,200.0** |
| **5** | **Хувь хүний орлогын албан татвар** | **17,362.0** | **17,753.0** | **20,953.0** | **3,200.0** |
| **6** | Цалин, хөдөлмөрийн хөлс... | 13,447.0 | 14,951.0 | 17,533.0 | 2,582.0 |
| **7** | Үйл ажиллагааны орлого | 1,053.6 | 550.0 | 968.0 | 418.0 |
| **8** | Хөрөнгө борлуулсны орлого | 453.4 | 452.0 | 452.0 | 0.0 |
| **9** | Шууд бус орлого | 909.1 | 370.0 | 570.0 | 200.0 |
| **10** | Хадгаламжийн хүүгийн татвар | 1,498.9 | 1,430.0 | 1,430.0 | 0.0 |
| **11** | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | -1,183.3 | -1,200.0 | -1,200.0 | 0.0 |
| **12** | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар | 481.3 | 990.0 | 990.0 | 0.0 |
| **13** | **Өмчийн татвар** | **3,470.9** | **1,363.2** | **3,342.3** | **1,979.1** |
| **14** | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 620.4 | 580.0 | 625.0 | 45.0 |
| **15** | Бууны албан татвар | 81.8 | 83.2 | 83.2 | 0.0 |
| **16** | Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар | 808.6 | 700.0 | 764.1 | 64.1 |
| **17** | Малд ногдуулах албан татвар | 1,960.0 | 0.0 | 1,870.0 | 1,870.0 |
| **17** | **Бусад татвар** | **5,339.7** | **4,171.4** | **4,656.9** | **485.5** |
| **18** | Улсын тэмдэгтийн хураамж | 552.1 | 513.0 | 613.0 | 100.0 |
| **19** | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 78.6 | 50.0 | 50.0 | 0.0 |
| **20** | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 1,341.0 | 912.7 | 1,247.7 | 335.0 |
| **21** | Газрын төлбөр | **824.3** | **529.7** | **580.2** | **50.5** |
| **22** | Үүнээс: Газрын төлбөр | 561.5 | 509.2 | 539.2 | 30.0 |
| **23** | Газрын дуудлага худалдаа | 262.9 | 20.5 | 41.0 | 20.5 |
| **24** | **Байгалийн нөөц ашигласны төлбөр Үүнээс:** | **2,543.7** | **2,166.0** | **2,166.0** | **0.0** |
| **25** | Ургамал ашигласны төлбөр | 60.6 | 20.0 | 20.0 | 0.0 |
| **26** | Ус рашааны нөөц ашигласны төлбөр | 66.3 | 66.0 | 66.0 | 0.0 |
| **27** | Ойн нөөц ашигласны төлбөр | 2,003.4 | 1,750.0 | 1,750.0 | 0.0 |
| **28** | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 413.4 | 330.0 | 330.0 | 0.0 |
| **29** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,319.0** | **1,625.2** | **2,308.5** | **683.3** |
| **30** | Ногдол ашиг | 528.1 | 22.0 | 322.0 | 300.0 |
| **31** | Хүүгийн орлого | 0.0 | 485.4 | 485.4 | 0.0 |
| **32** | Торгуулийн орлого | 1,306.5 | 1,100.0 | 1,100.0 | 0.0 |
| **33** | Түрээсийн орлого | 36.7 | 17.8 | 21.1 | 3.3 |
| **34** | Нэр заагдаагүй бусад орлого | 447.7 | 0.0 | 380.0 | 380.0 |
| **35** | **ХӨРӨНГИЙН ОРЛОГО** | **155.4** | **0.0** | **30.1** | **30.1** |
| **36** | Хөрөнгө борлуулсны орлого | 155.4 | 0.0 | 30.1 | 30.1 |
| **37** | НИЙТ ОРЛОГО: Үүнээс | **27,742.7** | **24,702.9** | **31,080.9** | **6,378.0** |
| | **АЙМГИЙН ОРЛОГО** | **3,240.4** | **1,728.0** | **2,454.8** | **726.8** |
| | **СУМЫН ОРЛОГО** | **24,502.3** | **22,974.8** | **28,626.1** | **5,651.2** |

Орон нутгийн 2024 оны төсвийн суурь орлогыг СЯ-ны хянасан дүнгээс нэмэгдүүлэн төлөвлөсөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Цалин, хөдөлмөрийн хөлс нэмэгдсэнтэй холбоотой Цалин, хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлогоос суутгах ХХОАТ-ын орлогыг 2,582.0 сая төгрөгөөр
- Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 24 сумын айл өрх, аж ахуйн нэгжийн төлбөрийн хэмжээнд үндэслэн 335.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- Малд ногдуулах албан татварын орлогыг 2024 оны төсвийн төсөлд тусгаж төлөвлөсөн.
- Могойн гол ХХК-аас ногдол ашгийн орлогод 300 сая төгрөгийг хуваарилахаар тооцсон.

- Нэр заагдаагүй бусад орлогоос 380.0 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлэхээр тооцож нэмэгдүүлсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

Хөвсгөл аймгийн 2024 оны төсвийн төслийн төлөвлөгөөг Сангийн яамны хянасан дүнгээс 6,378.0 сая төгрөгөөр буюу 20.5 хувиар нэмэгдүүлж батлахаар төлөвлөсөн байна.

*График №-1*




Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд суурь орлогыг аймгаас 2,454.8 сая төгрөг буюу 8 хувь, сумдаас 28,626.1 сая төгрөг буюу 92 хувийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Хөвсгөл аймгийн 2024 оны орон нутгийн төсвийн суурь орлогыг 31,080.9 сая төгрөг байхаар төлөвлөсөн байна.

*График №-2*




Графикаас харахад аймгийн нийт орлогын гүйцэтгэл жил бүр нэмэгдсэн байна.

Цалин, хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын татварын орлогын төлөвлөгөө урьд оноос 4,086.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн нийт орлогын төлөвлөгөө нэмэгдэхэд гол нөлөө үзүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн нийт орлогын 67 хувь буюу 20,453.0 сая төгрөгийг хувь хүний орлогын албан татварын орлогоос бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн ногдол ашгаас 322.0 сая төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн нь 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс 206.1 сая төгрөгөөр буурсан байна.

Хувь хүний албан татварын буцаан олголтыг 1,200.0 сая төгрөгөөр төлөвлөсөн нь нийт орлогын 3.9 хувьтай тэнцүү байна.

**Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:**

**Санал-1. Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого:**

Хөвсгөл аймгийн орон нутгийн 2024 оны төсвийн суурь орлогыг төлөвлөхдөө Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 17,033.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудын цалингийн мэдээллийг Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс авсан цалингийн сан, даатгуулагчдын тоон мэдээлэлд үндэслэн тооцоход Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос 18,053.7 сая

төгрөгийг бүрдүүлэх тооцоо гарч байна. /Тооцооллыг 2023 оны 09 дүгээр сарын цалингийн сангийн нийт дүнгээр тооцоолсон/.

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг **1,020.7 сая** төгрөгөөр **нэмэгдүүлэх** боломж байна. Х**авсралт № 1-ээс харах.**

*Сангийн яамны баталсан суурь орлогыг 6,378.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн ба аудитын хугацаанд орон нутгийн орлогыг 1,020.7 сая төгрөгөөр нэмэгдүүлэх санал хүргүүлж, 500.0 сая төгрөгийн саналыг хүлээн авч орон нутгийн төсвийн суурь орлогыг нэмэгдүүлсэн байна.*

### 2.2 Төсвийн төслийг нэгтгэн боловсруулахдаа ТЕЗ-ийн хяналтад байгаа байгууллагуудын төсвийн төслийн зардлыг ангиллаар нь гаргуулаагүй, бодит тооцоо судалгаанд үндэслэж, хяналт тавиагүй байна.

Хөвсгөл аймгийн 2024 оны төсвийн зарлагын төслийг нийт 93,651.9 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн байна. Үүнээс Урсгал зардалд 69,127.1 сая төгрөг, Хөрөнгийн зардалд 8,534.3 сая төгрөг, ОНХНС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд 15,990.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Аймгийн 2024 оны зардлын төсвийн төлөвлөлтийг УИХ-ын баталсан суурь хязгаартай харьцуулахад суурь зардлыг 9,290.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн суурь зардлын төсвийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт №-5* *сая.төг/*

| Үзүүлэлт | УИХ-ын баталсан | 2024 оны төсвийн төсөл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| | | | УИХ-ын баталснаас |
| **Урсгал зардал** | 64,512.9 | 69,127.1 | 4,614.2 |
| **Хөрөнгийн зардал** | 3,857.9 | 8,534.3 | 4,676.4 |
| **Нийт зардал** | **68,370.8** | **77,661.4** | **9,290.6** |

Урсгал зардлыг УИХ-ын баталсан дүнгээс 4,614.2 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 4,676.4 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Төсвийн зарлагын төслийг байгууллагаар хуваарилсныг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №-6* */сая.төг/*

| № | Байгууллагын нэр | | УИХ-ын баталсан | 2024 оны төсвийн төсөл | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| 1 | Аймгийн ИТХ | | 1,091.70 | 1,796.70 | 705.00 |
| 2 | Аймгийн ЗДТГ | | 6,777.00 | 10,395.00 | 3,618.00 |
| 3 | Сумдын ИТХ | | 4,244.20 | 3,745.70 | -498.50 |
| 4 | Сумдын ЗДТГ | | 22,301.50 | 22,555.20 | 253.70 |
| 5 | ЗД ерөнхий данс | | 3,326.40 | 4,520.10 | 1,193.70 |
| | | Мал эмнэлэг | 775.8 | 775.8 | - |
| | | Ус алдагдлын татаас | 302.9 | 302.9 | - |
| | | Авто замын сан | 1,409.3 | 2,148.6 | 739.3 |
| | | Цэвэрлэх байгууламжийн тогтмол | 201.1 | 201.1 | - |
| | | Ахмадын хороо | 64.5 | 64.5 | - |
| | | Дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлт | 485.4 | 985.4 | 500.0 |
| | | Нийтийн тээврийн алдагдалд олгох татаас | 45.6 | - | (45.6) |
| | | Агаарын бохирдлын эсрэг | 41.8 | 41.8 | - |
| 6 | Мал хамгаалах сан | | - | 102.5 | 102.5 |
| 7 | Орон нутгийн өмчийн газар | | 295.8 | 291.4 | (4.4) |
| 8 | ХАА | | - | 326.9 | - |
| 9 | Санхүүгийн хяналт, аудитын алба | | 304.7 | 304.7 | - |
| 10 | БОАЖГ | | 1,849.4 | 1,929.3 | 79.9 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11 | Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал | 1,723.3 | 2,128.3 | 405.0 |
| 12 | Ойн анги | 393.4 | 393.4 | - |
| 13 | Хот тохижилт үйлчилгээний төв | 1,449.9 | 1,495.5 | 45.6 |
| 15 | Халамжийн сан | 1,276.2 | 1,276.2 | - |
| 16 | Асрамжийн газар | 804.1 | 804.1 | - |
| 17 | Түрээсийн орон сууцны эргэлтийн сан | - | 27.3 | 27.3 |
| 18 | Соёл, спортын байгууллагын тогтмол зардал | 18,675.2 | 2,302.0 | 2,154.7 |
| 19 | Эрүүл мэндийн байгууллагын тогтмол зардал | | 2,578.5 | |
| 20 | Боловсролын байгууллагуудын тогтмол зардал | | 11,640.0 | |
| 21 | Орон нутгийн хөрөнгө оруулалт | - | 1,404.8 | 1,404.8 |
| 22 | Орон нутгийн хөрөнгө оруулалт /их засвар/ | 3,858.0 | 4,051.8 | 193.8 |
| 24 | Сумын ОНХС | 15,990.5 | 11,864.1 | 3,592.1 |
| 25 | АОНХС | | 7,718.4 | |
| **Дүн** | | **84,361.3** | **93,651.9** | **9,290.6** |

Хүснэгтээс харахад нийт зардлыг 9,290.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн ба энэ нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын төсвийг 705.0 сая төгрөгөөр, аймгийн ЗДТГ-ын төсвийг 3,618.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж орлого нэмэгдүүлэх болон санхүүгийн дэмжлэгээс санхүүжүүлэхээр
- Засаг дарга Ерөнхий дансыг 1,193.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүгийн дэмжлэгээс санхүүжүүлэхээр
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг 405.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, санхүүгийн дэмжлэгээс санхүүжүүлэхээр
- Соёл спорт, эрүүл мэнд, боловсролын байгууллагуудын тогтмол зардлыг 2,154.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж санхүүгийн дэмжлэгээс санхүүжүүлэхээр
- Орон нутгийн хөрөнгө оруулалтыг 1,404.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн орлого нэмэгдүүлэх болон 2023оны дансны үлдэгдлээс санхүүжүүлэхээр
- Их засварын зардлыг 193.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж орон нутгийн орлогоос санхүүжүүлэхээр
- Орон нутгийн хөгжлийн санг 3,592.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 2023 оны дансны үлдэгдлээс болон орон нутгийн орлогоос санхүүжүүлэхээр тус тус төлөвлөсөн байна.

МУ-ын Засгийн газраас 2024 онд цалин хөдөлмөрийн хөлсийг нэмэгдүүлэх чиглэлээр Хөвсгөл аймгийн 2024 оны Төсвийн төсөлд туссан цалин урамшууллын зардлыг тооцож үзэхэд 438.8 сая төгрөгөөр хэтрэлттэй байна. /Цалин урамшууллыг 2024 оны 4 сараас 10 хувиар нэмэгдүүлнэ, орон нутгийн нэмэгдлийг жилийн турш 100 хувиар, үр дүнгийн урамшууллыг улирал бүр 40 хувиар олгохоор тооцсон./ Үүнд:

1. Аймгийн ИТХ - 129.6 сая төгрөг,
2. Аймгийн ЗДТГ - 308 2 сая төгрөг

Энэ нь Төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөх зарчимтай нийцэхгүй байгаа тул тус урсгал зардлыг бууруулж, шаардлагатай хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд хуваарилах саналыг хүргүүлсэн.

Дээрх саналаас 129.6 сая төгрөгийн зардал бууруулах саналыг хүлээн хүлээн авахаар хариу ирүүлсэн.

Аудитаар дараах зөрчилтэй асуудлууд илэрлээ. Үүнд:

- Орон нутгийн 2024 оны Төсвийн төслийг нэгтгэн боловсруулахдаа ТЕЗ-ийн хяналтад байгаа байгууллагуудын төсвийн төслийн зардлыг ангиллаар нь гаргуулаагүй, бодит тооцоо судалгаанд үндэслэсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй.
- Цалин урамшууллын зардлыг нийт 438.8 сая төгрөгөөр хэтрүүлэн тооцсон.

Орон нутгийн төсвийн төслийг ирүүлэхдээ төсвийн ангиллын дагуу боловсруулсан төсвийн төслийн тооцоо, танилцуулгыг ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2.2 *“энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан төсвийн ангиллын дагуу боловсруулсан төсвийн төслийн тооцоо, танилцуулга”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

*Төсвийн төслийг нэгтгэн боловсруулахдаа ТЕЗ-ийн хяналтад байгаа байгууллагуудын төсвийн төслийн зардлыг ангиллаар нь гаргуулаагүй, цалин урамшууллыг 438.8 сая төгрөгөөр хэтрүүлэн тооцсон зэрэг нь бодит тооцоо судалгаанд үндэслэж, хяналт тавьж чадахгүй байгааг харуулж байна.*

## Бүлэг 3: Хөвсгөл аймгийн 2024 оны төсвийн төсөлд тусгасан хөрөнгө оруулалтын ихэнх төсөл арга хэмжээнүүд нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.

### 3.1 Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүд нь хуульд заасан шалгуурыг бүрэн хангахгүй байна.

Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, Замын сан, Их засварын хөрөнгө оруулалт болон байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар нийт 132 төсөл арга хэмжээнд 15,625.2 сая төгрөгийг зарцуулахаар төсөвлөсөн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт №-7: Хөрөнгө оруулалт* *Сая.төг*

| Хөрөнгө оруулалтын төрөл | Шилжих ТАХ | | | Шинээр хэрэгжих ТАХ | | | Нийт | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Төсөвт өртөг | Санхүүжих дүн | Тоо | Төсөвт өртөг | Санхүүжих дүн | Тоо | Дүн |
| Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт | 5 | 2,249.8 | 1,196.1 | 7 | 208.8 | 208.8 | 12 | 1,404.9 |
| Их засвар | 5 | 1,965.6 | 833.2 | 24 | 3,315.2 | 3,218.5 | 29 | 4,051.7 |
| Замын сан | 1 | 205.3 | 115.3 | 15 | 4,578.3 | 2,033.3 | 16 | 2,148.6 |
| Байгаль хамгаалах зардал | 2 | 195.3 | 195.3 | 7 | 189.5 | 189.5 | 9 | 384.8 |
| Орон нутгийн хөгжлийн сан | 7 | 3,352.5 | 1,071.5 | 59 | 10,045.0 | 6,563.7 | 66 | 7,635.2 |
| **Нийт** | **20** | **7,968.5** | **3,411.4** | **112** | **18,336.8** | **12,213.8** | **132** | **15,625.2** |

Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл,арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах журам”-д заасанаар төсвийн хөрөнгө оруулалтууд нь хэрэгцээ шаардлагатай, холбогдох зөвшөөрлийг /ус, дулаан, цахилгаа, газрын г.мэт/ авсан, магадлалаар баталгаажсан зураг төсөвтэй, урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон, тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, олон нийтээр хэлэлцүүлэгдсэн байх шаардлагатай байдаг.

***Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, их засвар, замын сан, БОХНСАХЗ-аар санхүүжих хөрөнгө оруулалтын тухайд:***

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд заасан шаардлагуудтай нийцүүлэн төлөвлөсөн эсэхэд хяналт хийхэд төсвийн хөрөнгө оруулалтын саналыг холбогдох байгууллагуудаас авсан боловч нийт төсөл арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлох ажлын баримтыг үүсгэж ажиллаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор

баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах журам”-ын 2.3.2.1[1] дэх заалтыг зөрчиж байна.

2. Зураг төсөв шаардлагатай их засварын 24 төсөл, арга хэмжээнээс 1,537.9 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээ зураг, төсөвгүй /хавсралт 3/ байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29[1] дүгээр зүйлийн 29[2].2.2 “*барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх*” болон Төрийн хэмнэлтийн тухай хууль 13 дугаар зүйлийн 13.3.3-т “*Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно: техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ*” гэж заасныг зөрчиж байгаа бөгөөд төсөл, арга хэмжээ хүссэн үр дүнд хүрэхгүй байх эрсдэлийг дагуулж байна.

3. Төсвийн хөрөнгө оруулалтад төлөвлөсөн аймгийн ЗДТГ-т авто машин худалдан авах 85.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх хянах, тайлагнах журам”-ын 3.1.3-т заасан зайлшгүй хэрэгцээ шаардлагатай болох нь холбогдох нотлох баримтаар нотлогдохгүй, мөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хязгаарлалттай нийцэхгүй байна.

4. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос гадаад улсад туршлага судлахад 8.0 сая төгрөг, 2 автомашин худалдан авах 155.0 сая төгрөгийн нийт 163.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна. Энэ нь Засгийн газрын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 3.2 , Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хязгаарлалттай нийцэхгүй байна.

5. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд 119.4 сая төгрөгөөр худалдан авсан Нийтийн ариун цэврийн байгууламжийн барилга /Мөрөн сум 8-р баг/-ын үнэлгээний зөрүү 20.0 сая төгрөгийг олгохоор төсвийн төсөлд тусгасан байна. Энэ нь:

   - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 41 дүгээр зүйл 41.2-т *“Худалдан авах гэрээнд дараах өөрчлөлт хийхийг хориглоно”* энэ хуулийн 40.4, 40.6-д заасныг бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөх”,
   - Аймгийн Засаг дарга, “Уул-Өвгөд”ХХК-ийн хооронд 2022 оны 11 сарын 21-ний өдөр байгуулсан “Нийтийн ариун цэврийн байгууламжийн барилга худалдан авах/Мөрөн сум, баяр наадмын талбай/ гэрээ”-ний 1-т “Энэ гэрээний дагуу нийлүүлэгчийн хооронд Нийтийн ариун цэврийн байгууламжийн барилга худалдан авах/Мөрөн сум, баяр наадмын талбай/ барааны үнэ нь 119.4 сая төгрөг цаашид “гэрээний үнэ” гэх/ байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна”
   - Гэрээний 5.9-т “Зайлшгүй шаардлагаар гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага гарвал талууд харилцан тохиролцож гэрээний үнэ, барааны техникийн тодорхойлолтоос бусад асуудлаар зохих өөрчлөлт оруулж болох

[1] *орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангилалтай ижил байдлаар хэрэгжүүлж, тайлагнах;*

бөгөөд тус өөрчлөлтийг бичгээр гаргаж талууд баталгаажуулсан нөхцөлд хүчин төгөлдөр болсонд тооцно” гэж заасныг тус тус зөрчиж байна.

***Орон нутгийн хөгжлийн сангийн тухайд:***

ОНХНС-аас Хөвсгөл аймгийн орон нутгийн хөгжлийн санд 15,990.5 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс аймгийн ОНХС-д 5,996.4 сая төгрөг, сумын ОНХС-д 9,994.1 сая төгрөг зарцуулахаар хуваарилсан байна.

Аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг аймгийн ЗДТГ-ын даргын 2022/05/13-ны өдрийн А/165 дугаартай тушаалаар байгуулсан орон тооны бус ажлын хэсэг бэлтгэсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд 6,563.6 сая төгрөгөөр шинээр хэрэгжүүлэх 59 төсөл арга хэмжээ, 1,071.5 сая төгрөгийн 7 шилжих төсөл арга хэмжээг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Үүнээс иргэдийн санал дэмжигдсэн, зураг төсөвтэй байх шаардлагагүй (Зураг төсвийн сан, Баяр наадмын зардал) 2 төсөл арга хэмжээ байна. Бусад 57 төсөл арга хэмжээ нь хууль, журамд заасан шаардлагыг хангасан байх нь зүйтэй.

Аймгийн 2024 оны төсвийн төсөлд тусгасан төсөл арга хэмжээ иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн, зураг төсөлтэй байх шалгуур үзүүлэлтийг хангасан байдлыг графикаар харуулбал дараах байдалтай байна. *График №-3*




Графикаас харахад нийт төсөл арга хэмжээний **84 хувь нь** иргэдийн саналаар дэмжигдэж, зураг төсөвтэй байх шалгуурыг хангаагүй байна. Мөн урьдчилсан жагсаалтыг эрэмбэлэх ажлын хэсгийн хурлаар 665.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 9 төсөл арга хэмжээг тус жагсаалтад нэмж оруулан эрэмбэлсэн нь СС-ын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам-ын 4 дүгээр зүйлийн 4.3.2.”*ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд гүйцэтгэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ нь хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Хавсралт №5

*Хүснэгт №-8* */сая.төг/*

| № | Зөрчлийн агуулга | ТАХ-ний тоо | 2024 онд санхүүжих дүн /сая.төг/ | Нийцээгүй хуулийн заалт |
|---|---|---|---|---|
| **1** | | 46 | 4,852.0 | Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 *“орон нутгийн иргэдийн саналыг аваагүй ...”* |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Иргэдийн саналаар дэмжигдээгүй | | | Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.2, 4.3.2, 4.7.5 |
| **2** | Зураг төсөвгүй | 45 | 4,307.5 | Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 *“Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.”* |
| | | | | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3 *“техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.”* |
| | | | | Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаал “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.3 *“ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх;”* |
| **3** | Ашиглалтын зардлын тооцоололгүй, төсөвт нөлөөлөх нөлөөлөл тооцоогүй | 57 | 6,142.0 | Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 *“Хөрөнгө оруулалтын төслийн санал үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.”* |
| **4** | Төрийн хэмнэлтийн хуульд нийцээгүй | 1 | 270.3 | Угтах үдэх хаалга орчмын тохижилтын ажил /Мөрөн сум/ төсөвт өртөг 270.3 сая төгрөг. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 *“хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах”* |
| | | 1 | 90.0 | Цэвэр усны ухаалаг тоолуур худалдан авах /Ус суваг/. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2. “*хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ.”* |

Өмнөх аудитаар дээрх зөрчилд зөвлөмж, албан шаардлага хүргүүлсэн бөгөөд тус зөрчлийн тоо, хэмжээ буурсан үзүүлэлттэй байсан боловч 2024 оны төсвийн төсөлд зөрчил өссөн үзүүлэлттэй төлөвлөгдсөн байна.

***Замын сангийн тухайд:***

Хөвсгөл аймгийн замын сангийн хөрөнгөөр 2024 онд 4,783.6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 15 төсөл, арга хэмжээнд 2,148.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн ба үнээс 1,928.3 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээ зураг төсөвгүй байна. Хавсралт №4

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн $29^{1}$ дүгээр зүйлийн $29^{1}$.2.2[3] болон Төрийн хэмнэлтийн тухай хууль 13 дугаар зүйлийн 13.3.3[4], Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4[5] дахь заалтыг тус зөрчиж байна.

[3] *барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;*

[4] *Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно: техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.*

[5] *Авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг магадлалын дүгнэлт бүхий баталгаажсан зураг төсөлгүй, техник, технологийн хяналтгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.*

***Азийн хөгжлийн банк, Дэлхийн банкны төслийн урт хугацаат зээлийн эх үүсвэрээр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийн тухайд:***

Тус зээлийн 2024 онд төлөх 985.4 сая төгрөгийн эргэн төлөлтийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс төлөхөөр төсөвлөсөн байна. Монгол улсын Засгийн газраар дамжуулан гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын зээлийн төлбөрт 985.4 сая төгрөгийн эргэн төлөлтийг санхүүгийн дэмжлэгээс төлөхөөр төсөвлөсөн нь орон нутгийн төсөвт хүндрэл учруулахаар байна.

### 3.2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 41.6 хувьтай байна.

Төрийн аудитын байгууллага Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу өмнөх аудитын тайланд дурдсан асуудал, зөвлөмжийн мөрөөр хариуцагч талын авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийх үүрэгтэй.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт №-9*

| № | Зөвлөмжийн утга | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|
| | **Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргад** | |
| **1** | Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан зарчим, шаардлагад нийцсэн төсвийн төслийг хэлэлцүүлэн батлах | 50 |
| | **Аймгийн Засаг даргад** | |
| **1** | Аймгийн орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын хэрэгжилт, нэгдсэн удирдлагаар хангаж, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдааг сайжруулан төсвийн төлөвлөлтийг хууль журамд нийцүүлэн төлөвлөөгүй холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцон ажиллах | 0 |
| **2** | Төрийн аудитын байгууллагаас ирүүлсэн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах санал хүлээн авч төсвийн төсөлд тусгах | 100 |
| **3** | Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл арга хэмжээг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн төсвийн төсөлд тусгах | 0 |
| **4** | Хөрөнгө оруулалтын чанарыг сайжруулах, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, хэрэгцээ шаардлагатай хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх, үргүй зардлыг бууруулахад анхаарч ажиллах | 50 |
| **5** | Аймгийн ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-нийцүүлэн төлөвлөж байх | 50 |
| | **Дундаж хувь** | **41.6** |

Хөвсгөл аймгийн орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт өгсөн аудитаар аймгийн ИТХ-ын даргад 1 зөвлөмж, Засаг даргад 5 зөвлөмж хүргүүлснээс 1 зөвлөмж хэрэгжиж, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, 4 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт 41.6 хувьтай байна.

*Аудитын явцад орон нутгийн төсвийн суурь орлогыг нэмэгдүүлэх 500.0 сая төгрөг, зардал бууруулах 129.6 сая төгрөгийн саналыг тус тус хүлээн зөвшөөрүүлж, хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн шаардлага хангаагүй 4,850.6 сая төгрөгийн 44, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих 6,142.0 сая төгрөгийн 57 төсөл арга хэмжээг төсвийн төлөвлөлтөөс хасаж, хууль, журамд нийцсэн, шаардлага хангасан, үр ашигтай хөрөнгө оруулалтад зарцуулах саналыг хүргүүлж байна.*

## ДҮГНЭЛТ:

**Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.**

1. Хөвсгөл аймгийн 2024 оны төсвийн төсөлд 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй хөрөнгө оруулалтын 23 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь аймгийн хөгжлийн бодлогыг дэмжихгүй байна.
2. УИХ-аас баталсан Хөвсгөл аймгийн орон нутгийн 2024 оны төсвийн орлого, зардлыг 6,378.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, орлогыг 93,651.9 сая төгрөг, зардлыг 93,651.9 сая төгрөг болгосноор төсвийн тэнцэл хангагдсан байна.
3. Орон нутгийн 2024 оны төсвийн төслийг бодит тооцоо судалгаа, үр дүнд суурилсан арга аргачлалаар, тооцож боловсруулаагүй, хөтөлбөр, арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг тоон болон чанарын утгаар хэмжигдэхүйцээр бодитой тодорхойлоогүйгээс төсвийн зорилго хангагдах эсэхийг үнэлэх боломжгүй болгож цаашид төсвийг хэмнэлтгүй байдлаар зарцуулах нөхцөл байдлыг бий болгож, төсвийн үр ашгийг бууруулах эрсдэлтэй байна.
4. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС, замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнүүдийг төлөвлөхдөө хууль, журамд заасан төсөвлөлтийн шаардлагыг бүрэн хангуулаагүй, дийлэнх төсөл арга хэмжээнүүд нь зураг төсөвгүй байгаа нь хөрөнгө оруулалтын төлөвлөсөн үр дүнг бууруулах эрсдэлтэй ба хуулийн хэрэгжилтийг хангахгүй байгааг харуулж байна.
5. Төрийн аудитын байгууллагаас орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сан, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагааны зардлаар санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Авто замын тухай хууль болон бусад хууль, журмын холбогдох заалтуудын дагуу боловсруулж ажиллах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй холбогдох албан хаагчидтай хариуцлага тооцон ажиллахгүй байгаагаас зөрчил дутагдал давтагдаж байна.
6. Монгол улсын Засгийн газраар дамжуулан гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын зээлийн төлбөрт 985.4 сая төгрөгийн эргэн төлөлтийг санхүүгийн дэмжлэгээс төлөхөөр төлөвлөсөн нь орон нутгийн төсөвт хүндрэл учруулахаар байна.

## ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

**Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргад:**

1. Орон нутгийн төсвийг хэлэлцэн батлахдаа хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийг аймгийн дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэхэд анхаарах
2. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамд заасан зарчим, шаардлагад нийцсэн төсвийн төслийг хэлэлцүүлэн батлах.

**Хөвсгөл аймгийн Засаг даргад:**

1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийг тухай жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх.
2. Орон нутгийн төсвийн төсөл боловсруулахдаа хууль журамд заасан үндсэн шаардлагатай нийцүүлэн боловсруулж, холбогдох баримт материалын хамт аймгийн ИТХ болон Төрийн аудитын газарт хүргүүлж байх
3. Төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө хууль, журамд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангасан зураг төсөв, хүрэх үр дүнг тодорхойлсон төсөл, арга хэмжээнүүдийг тусгах.
4. Хөрөнгө оруулалтын чанарыг сайжруулах, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, хэрэгцээ шаардлагатай хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх, үр дүнг дээшлүүлэхэд анхаарч ажиллах.
5. Төсвийн төсөл боловсруулах үйл явцад хууль, журмын холбогдох заалтыг зөрчин шаардлага хангахгүй төсвийн төлөвлөлт хийсэн холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцон ажиллах
6. Хөвсгөл Ус суваг ХХК болон Хөвсгөл Эрчим хүч ХХК-ийн 2024 оны бизнес төлөвлөгөөнд дамжуулан зээлдүүлэхийн зээлийн төлбөрт төлөхөөр тусгасан 985.4 сая төгрөгийг тусгаж, зээлийн төлбөрийг төлүүлэн төсөвт ирэх хүндрэлийг бууруулах
7. Орон нутгийн 2024 оны Төсвийн төслийг нэгтгэн боловсруулахдаа ТЕЗ-ийн хяналтад байгаа байгууллагуудын төсвийн төслийн зардлын ангиллаар нь гаргуулж зардлыг бодит тооцоонд үндэслэсэн эсэхэд хяналт тавьж нэгтгэн боловсруулж байх

## Зөрчлийн нэгтгэл

| № | Үзүүлэлт | Дүн сая.төг | Санал | Зөвлөмжийн тоо | Зөвлөмжийн дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийг тухай жилийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөөгүй. | - | | **2** | - |
| **2** | Хууль, журамд заасан зарчим, шаардлагад нийцсэн төсвийн төслийг боловсруулаагүй байна. | - | | **1** | |
| **3** | Төсвийн төслийг нэгтгэн боловсруулахдаа ТЕЗ-ийн хяналтад байгаа байгууллагуудын төсвийн төслийн зардлыг ангиллаар нь гаргуулаагүй, цалин урамшууллыг хэтрүүлэн тооцсон, бодит тооцоо судалгаанд үндэслэж, хяналт тавьж ажиллаагүй. | **-** | | 1 | - |
| **4** | Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 66 төсөл арга хэмжээнээс 1,661.1 сая төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг Хөвсгөл аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгаагүй байна | 274.9 | Хууль журмын хэрэгжилтийг хангуулах | 1 | 274.9 |
| **5** | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 841.5 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээнүүд нь аймгийн орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг /ЗДҮАХ/-т нийцээгүй байна | 841.5 | Хууль журмын хэрэгжилтийг хангуулах | 1 | 841.5 |
| **6** | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг **1,020.7 сая** төгрөгөөр **нэмэгдүүлэх** боломж байна. | 1,020.7 | 1,020.7 | - | - |
| **7** | Орон нутгийн 2024 оны төсвийн төслийг нэгтгэн боловсруулахдаа ТЕЗ-ийн хяналтад байгаа байгууллагуудын төсвийн төслийн зардлыг ангиллаар нь гаргуулаагүй, бодит тооцоо судалгаанд үндэслэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй | - | - | 1 | - |
| **8** | Цалин урамшууллын зардлыг хэтрүүлэн тооцсон. | 438.8 | 438.8 | - | - |
| **9** | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг Төсвийн тухай хуульд заасан шаардлагуудтай нийцүүлэн төлөвлөсөн эсэхэд хяналт хийхэд төсвийн хөрөнгө оруулалтын саналыг холбогдох байгууллагуудаас авсан боловч нийт төсөл арга хэмжээ нь төсөвлөлтийн шаардлагыг хангасан эсэхийг тодорхойлох ажлын баримтыг үүсгэж ажиллаагүй байна. | - | | 1 | - |
| **10** | Их засварын 1,537.9 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээ зураг, төсөвгүй байна. | 1,537.9 | Хууль журмын хэрэгжилтийг хангуулах | - | - |
| **11** | Төсвийн хөрөнгө оруулалтад төлөвлөсөн аймгийн ЗДТГ-т авто машин худалдан авах 85.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг | 85.0 | Хууль журмын хэрэгжилтийг хангуулах | - | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцэхгүй байна. | | | | |
| **12** | Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын ойн нөөц ашигласны төлбөрийн орлогоос гадаад улсад туршлага судлахад 8.0 сая төгрөг, 2 автомашин худалдан авах 155.0 сая төгрөгийн нийт 163.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн байна. | 163.0 | Хууль журмын хэрэгжилтийг хангуулах | - | - |
| **13** | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд 119.4 сая төгрөгөөр худалдан авсан Нийтийн ариун цэврийн байгууламжийн барилга /Мөрөн сум 8-р баг/-ын үнэлгээний зөрүү 20.0 сая төгрөгийг олгохоор төсвийн төсөлд тусгасан байна. | 20.0 | Хууль журмын хэрэгжилтийг хангуулах | - | - |
| **14** | Замын сангийн хөрөнгөөр 2024 онд шинээр хэрэгжих 1,928.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл арга хэмжээ нь зураг, төсөвгүй байна. | 1,928.3 | Хууль журмын хэрэгжилтийг хангуулах | - | - |
| **15** | Монгол улсын Засгийн газраар дамжуулан гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын зээлийн төлбөрт 985.4 сая төгрөгийн эргэн төлөлтийг санхүүгийн дэмжлэгээс төлөхөөр төсөвлөсөн байна. | 985.4 | | 1 | 985.4 |
| **16** | ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 46 ТАХ иргэдийн саналаар дэмжигдээгүй | 4,852.0 | Хууль журмын хэрэгжилтийг хангуулах | - | - |
| **17** | ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 45 ТАХ зураг төсөвгүй байна. | 4,307.5 | Хууль журмын хэрэгжилтийг хангуулах | - | - |
| **18** | ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 57 ТАХ Ашиглалтын зардлын тооцоололгүй, төсөвт нөлөөлөх нөлөөлөл тооцоогүй | 6,142.0 | Хууль журмын хэрэгжилтийг хангуулах | - | - |
| **19** | Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй. | 360.3 | Хууль журмын хэрэгжилтийг хангуулах | - | - |
| **Дүн** | | **22,957.3** | | **9** | **2,101.8** |

***ХАВСРАЛТ №1***

**Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын тооцоолол**

*Төгрөгөөр*

| код | 1 сард | НДШ | Татвар тооцох | Татвар 10 хувь | Шимтгэл төлөгчийн тоо | Татварын хөнгөлөлт /1 сард/ | Нийт хөнгөлөлт | Суутгах татварын дүн /1 сар/ | Нийт сар | Нийт суутгах татварын дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 293,331,449 | 33,733,117 | 259,598,332 | 25,959,833 | 415 | 16,000 | 6,640,000 | 19,319,833 | 12 | 231,837,998 |
| 21 | 53,024,286 | 6,097,793 | 46,926,493 | 4,692,649 | 112 | 16,000 | 1,792,000 | 2,900,649 | 12 | 34,807,791 |
| 1 | 231,804,913 | 26,657,565 | 205,147,348 | 20,514,735 | 173 | 16,000 | 2,768,000 | 17,746,735 | 12 | 212,960,817 |
| 9 | 2,748,109,960 | 316,032,645 | 2,432,077,315 | 243,207,731 | 3,407 | 16,000 | 54,512,000 | 188,695,731 | 12 | 2,264,348,777 |
| 15 | 77,056,473 | 8,861,494 | 68,194,979 | 6,819,498 | 334 | 16,000 | 5,344,000 | 1,475,498 | 12 | 17,705,974 |
| 13 | 9,842,632 | 1,131,903 | 8,710,729 | 871,073 | 16 | 16,000 | 256,000 | 615,073 | 12 | 7,380,875 |
| 8 | 371,203,081 | 42,688,354 | 328,514,727 | 32,851,473 | 87 | 16,000 | 1,392,000 | 31,459,473 | 12 | 377,513,672 |
| 3 | 12,692,188,024 | 1,459,601,623 | 11,232,586,401 | 1,123,258,640 | 8,442 | 16,000 | 135,072,000 | 988,186,640 | 12 | 11,858,239,681 |
| 12 | 163,397,465 | 18,790,708 | 144,606,757 | 14,460,676 | 92 | 16,000 | 1,472,000 | 12,988,676 | 12 | 155,864,107 |
| 2 | 805,054,571 | 92,581,276 | 712,473,295 | 71,247,330 | 913 | 16,000 | 14,608,000 | 56,639,330 | 12 | 679,671,954 |
| 11 | 35,600,000 | 4,094,000 | 31,506,000 | 3,150,600 | 57 | 16,000 | 912,000 | 2,238,600 | 12 | 26,863,200 |
| 4 | 1,894,291,418 | 217,843,513 | 1,676,447,905 | 167,644,790 | 271 | 16,000 | 4,336,000 | 163,308,790 | 12 | 1,959,705,485 |
| 5 | 138,973,789 | 15,981,986 | 122,991,803 | 12,299,180 | 124 | 16,000 | 1,984,000 | 10,315,180 | 12 | 123,782,163 |
| 10 | 292,649,597 | 33,654,704 | 258,994,893 | 25,899,489 | 1,082 | 16,000 | 17,312,000 | 8,587,489 | 12 | 103,049,872 |
| **Дүн** | **19,806,527,658** | **2,277,750,681** | **17,528,776,977** | **1,752,877,698** | **15,525** | | **248,400,000** | **1,504,477,698** | | **18,053,732,373** |

| № | Татвар | 2024 оны төсвийн төсөл | Аудитаар | Орлого нэмэгдүүлэх боломжит дүн |
|---|---|---|---|---|
| 1 | Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 17,033,000,000 | 18,053,732,373 | **1,020,732,373** |

***ХАВСРАЛТ №2***

**Хөвсгөл аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт**

| № | Санхүүжилтийн эх үүсвэр | Төсвийн дугаар | Төсөл арга хэмжээний нэр | Төсөвт өртөг /сая төгрөг/ | 2024 онд санхүүжих дүн /сая төгрөг/ | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа | Бодлогын баримт бичигт тусгагдсан байдал | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Таван жилийн чиглэл | АЗДҮАХ | Хөвсгөл аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө |
| 1 | Их засвар | 2.1.17 | Сумын эрүүл мэндийн төвийн барилгын засвар /Эрдэнэбулган сум/ | 50.0 | 50.0 | 2024 | 2024 | 2.2.8 | 2.1.11 | Тусгагдаагүй |
| 2 | | 2.1.18 | 150 хүүхдийн дотуур байрны гал тогооны засвар /Баянзүрх сум/ | 82.5 | 82.5 | 2024 | 2024 | 2.1.8 | 2.3.10 | Тусгагдаагүй |
| 3 | | 2.1.19 | 150 хүүхдийн дотуур байрны өрөөний засвар /Баянзүрх сум/ | 20.0 | 20.0 | 2024 | 2024 | 2.1.8 | 2.3.10 | Тусгагдаагүй |
| 4 | | 2.1.20 | Дээд модот буланд Эрүүл мэндийн цэгийн засвар /Хатгал/ | 19.9 | 19.9 | 2024 | 2024 | 2.2.8 | 2.1.11 | Тусгагдаагүй |
| 5 | | 2.1.21 | Хүүхдийн цэцэрлэгийн дээврийн засвар /Шинэ-Идэр сум/ | 150.0 | 150.0 | 2024 | 2024 | 2.1.8 | 2.3.8 | Тусгагдаагүй |
| 6 | | 2.1.22 | Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн хөл бөмбөгийн талбайн засвар | 216.8 | 120.0 | 2024 | 2025 | 2.1.8 | 2.3.8 | Тусгагдаагүй |
| 7 | | 2.1.23 | Дотуур байрны засвар /Чандмань-Өндөр сум/ | 20.0 | 20.0 | 2024 | 2024 | 2.1.8 | 2.3.8 | Тусгагдаагүй |
| 8 | | 2.1.24 | Хүүхдийн цэцэрлэгийн дээврийн их засвар /Мөрөн сум 8-р баг/ | 100.0 | 100.0 | 2024 | 2024 | 2.1.8 | 2.3.8 | Тусгагдаагүй |
| 9 | ОНТХО | 2.1.2 | Автомашин худалдан авах /ЗДТГ/ | 70.0 | 70.0 | 2024 | 2024 | 5.3.6 | 4.2.6 | Тусгагдаагүй |
| 10 | Замын сан | 2.1.10 | Ирээдүй сургууль хүртэл зам тавих 300 метр | 450.0 | 200.0 | 2024 | 2025 | 8.2.1 | 3.9.2 | Тусгагдаагүй |
| 11 | | 2.1.11 | Чигжийн голын гүүр барих /Бүрэнтогтох сум, Урандөш зуслан/ | 58.3 | 58.3 | 2024 | 2024 | 8.2.1 | 3.9.2 | Тусгагдаагүй |
| 12 | | 2.1.15 | Онцгой байдлын газар хүртэлх зам тавих 250 метр | 250.0 | 150.0 | 2024 | 2025 | 8.2.1 | 3.9.2 | Тусгагдаагүй |
| 13 | Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга | 1 | Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын санаачлан хэрэгжүүлж буй "Мод тарьж ногоон суварга босгоё" аяны хүрээнд гадаад улсад туршлага судлах | 8.0 | 8.0 | 2024 | 2024 | 6.2.1 | 5.1.4 | Тусгагдаагүй |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | хэмжээний зардал | 2 | Байгаль хамгаалах нөхөрлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | 5.0 | 5.0 | 2024 | 2024 | 6.2.5 | 5.1.6 | Тусгагдаагүй |
| 15 | | 3 | Байгаль орчин, аялал жуулчлалын газрын хяналт шалгалтын ажлын зардал | 5.6 | 5.6 | 2024 | 2024 | 6.2.2 | 5.1.5 | Тусгагдаагүй |
| 16 | | 4 | Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын санаачлан хэрэгжүүлж буй "Мод тарьж ногоон суварга босгоё" аяны хүрээнд ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлд хяналт тавих туулах чадвар сайтай автомашин худалдан авах | 55.0 | 55.0 | 2024 | 2024 | 6.2.5 | 5.1.9 | Тусгагдаагүй |
| 17 | | 6 | Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, мод тарьж ногоон суварга босгоё аяны хүрээнд Мөрөн сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 100.0 сая төгрөгийг тендерт гүйцэтгэгч шалгараагүй тул БОАЖГ-т туулах чадвар сайтай авто машин худалдан авах зардалд шилжүүлэх | 100.0 | 100.0 | 2023 | 2024 | 6.2.5 | 5.1.9 | Тусгагдаагүй |
| **Нийт** | | | | **1,661.1** | **1,214.3** | | | | | |

**ХАВСРАЛТ №3**

## Их засварын ажлын зураг, төсөвгүй төсөл арга хэмжээний жагсаалт

мян.төг

| № | Төсвийн дугаар | Төсөл арга хэмжээний нэр | Төсөвт өртөг мян.төг | 2024 онд санхүүжих дүн | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2.1.1 | Хүүхдийн цэцэрлэгийн барилгын дулаалга, сангийн засвар /Хатгал тосгон/ | 200,000.0 | 200,000.0 | 2024 | 2024 |
| 2 | 2.1.2 | Спорт заалны засвар /Цагаан-Үүр сум/ | 80,000.0 | 80,000.0 | 2024 | 2024 |
| 3 | 2.1.3 | Хүүхдийн цэцэрлэгийн барилгын дулаалга засвар /Арбулаг сум/ | 100,000.0 | 100,000.0 | 2024 | 2024 |
| 4 | 2.1.10 | Хөгжимт драмын театрын дотор засвар | 100,000.0 | 100,000.0 | 2024 | 2024 |
| 5 | 2.1.11 | Соёлын төвийн засвар/Тосонцэнгэл сум/ | 200,000.0 | 200,000.0 | 2024 | 2024 |
| 6 | 2.1.12 | Аймгийн баяр наадмын талбайн хиймэл ногоон зүлэг, гүйлтийн зам үзэгчдийн саравч, сандал солих засвар шинэчлэлтийн ажил | 250,000.0 | 250,000.0 | 2024 | 2024 |
| 7 | 2.1.13 | "Урандөш" хүүхдийн зуслангийн байруудын их засвар | 217,957.3 | 217,957.3 | 2024 | 2024 |
| 8 | 2.1.16 | Сумын эрүүл мэндийн төвийн барилгын засвар /Цагааннуур сум/ | 30,000.0 | 30,000.0 | 2024 | 2024 |
| 9 | 2.1.17 | Сумын эрүүл мэндийн төвийн барилгын засвар /Эрдэнэбулган сум/ | 50,000.0 | 50,000.0 | 2024 | 2024 |
| 10 | 2.1.19 | 150 хүүхдийн дотуур байрны өрөөний засвар /Баянзүрх сум/ | 20,000.0 | 20,000.0 | 2024 | 2024 |
| 11 | 2.1.20 | Дээд модот буланд Эрүүл мэндийн цэгийн засвар /Хатгал/ | 19,900.0 | 19,900.0 | 2024 | 2024 |
| 12 | 2.1.21 | Хүүхдийн цэцэрлэгийн дээврийн засвар /Шинэ-Идэр сум/ | 150,000.0 | 150,000.0 | 2024 | 2024 |
| 13 | 2.1.23 | Дотуур байрны засвар /Чандмань-Өндөр сум/ | 20,000.0 | 20,000.0 | 2024 | 2024 |
| 14 | 2.1.24 | Хүүхдийн цэцэрлэгийн дээврийн их засвар /Мөрөн сум 8-р баг/ | 100,000.0 | 100,000.0 | 2024 | 2024 |
| **Нийт** | | | **1,537,857.3** | **1,537,857.3** | | |

**Хавсралт №4**

## Замын сангийн хөрөнгөөр хийгдэх зураг төсөвгүй төсөл, арга хэмжээний жагсаалт

| № | Төсвийн дугаар | Төсөл арга хэмжээний нэр | Төсөвт өртөг |
|---|---|---|---|
| 1 | 2.1.1 | Сумын төвийн зам засвар арчлалт /Галт сум/ | 150.0 |
| 2 | 2.1.2 | Сумын төвийн зам засвар арчлалт /Их-Уул сум/ | 100.0 |
| | | | |
| 3 | 2.1.3 | Баян бэлчир, Суухайн даваа засвар /Тариалан сум/ | 60.0 |
| 4 | 2.1.4 | Хасгийн дөрөлжийн зам засвар /Түнэл сум/ | 80.0 |
| 5 | 2.1.5 | Тоомын давааны зам засвар / Улаан-Уул сум/ | 150.0 |
| 6 | 2.1.8 | Сумын төвийн 2.5км зам засвар арчлалт /Ханх сум/ | 80.0 |
| 7 | 2.1.9 | Мөрөн сумын Төв гандан хүртэл зам тавих /Мөрөн сум 1-р баг/ 100 метр | 150.0 |
| 8 | 2.1.10 | Ирээдүй сургууль хүртэл зам тавих 300 метр | 450.0 |
| 9 | 2.1.11 | Чигжийн голын гүүр барих /Бүрэнтогтох сум, Урандөш зуслан/ | 58.3 |
| 10 | 2.1.12 | Шивэрт бумбатын давааны зам засвар, арчлалт /Шинэ-Идэр сум/ | 150.0 |
| 11 | 2.1.13 | Сумын төвийн зам засвар /Тосонцэнгэл сум/ | 150.0 |
| 12 | 2.1.14 | Мөрөн сум доторх зам засвар арчилгаа | 100.0 |
| 13 | 2.1.15 | Онцгой байдлын газар хүртэлх зам тавих 250 метр | 250.0 |
| **Нийт** | | | **1,928.3** |

***ХАВСРАЛТ №5***

## ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хууль журмын нийцэл

| № | Төсөл, арга хэмжээний нэр байршил | 2024 онд санхүүжих дүн Сая.төг | Иргэдийн саналыг авсан эсэх | Зураг төсөвтэй эсэх | Урсгал зардал, төсөвт нөлөөлөх нөлөөлөл тооцсон эсэх |
|---|---|---|---|---|---|
| 1 | Бүрэнхаан цэцэрлэгийн баруун хойд талын хатуу хучилттай авто замаас Цахим худаг хүртэлх зам тавих. | 400.0 | Тийм | үгүй | үгүй |
| 2 | Аймгийн "Авто зам"-ыг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх /Хилэнтийн гүүрнээс наашаа Мөрөнгийн чиглэлд чиглэлд 1.0 км хатуу хучилттай авто зам/ | 500.0 | үгүй | үгүй | үгүй |
| 3 | Цэцэрлэгийн тоглоомын талбайн тохижилтыг нэмэгдүүлэх /Мөрөн сум 15 цэцэрлэгт/ | 80.0 | үгүй | үгүй | үгүй |
| 4 | "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг хэрэгжүүлэх | 20.0 | үгүй | үгүй | үгүй |
| 5 | "Амгалан амьдрал" арга хэмжээний хүрээнд архины хамааралтай иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх, сургалт сурталчилгаанд хамруулах | 30.0 | үгүй | үгүй | үгүй |
| 6 | Эрт илрүүлэг үзлэгт иргэдийг үе шаттайгаар хамруулах ажлын хүрээнд зөөврийн эхо аппарат худалдан авах /Нэгдсэн эмнэлэг/ | 120.0 | үгүй | үгүй | үгүй |
| 7 | "Эрүүл шүд Эрүүл ахуй" арга хэмжээний төлөвлөгөөг  хэрэгжүүлэх | 90.0 | үгүй | үгүй | үгүй |
| 8 | ЭМТ-ийн барилгын дулаан, цэвэр усны зардал дуусгах /Тариалан сум/ | 90.0 | үгүй | үгүй | үгүй |
| 9 | Мөрөн сумын "Хийморийн овооны тохижилтын ажил эхлүүлэх" /Мөрөн сум/ | 150.0 | үгүй | тийм | үгүй |
| 10 | Соёлын төвийн техник хэрэгсэл шинэчлэх /Тосонцэнгэл сум/ | 100.0 | Тийм | тийм | үгүй |
| 11 | Ахмад настны чийрэгжүүлэлтийн гадна талбайн тоног төхөөрөмж худалдан авах /Мөрөн сум, 7-р баг/ | 50.0 | Тийм | тийм | үгүй |
| 12 | Техник хэрэгсэл /Цагдаагийн газар/ | 50.0 | үгүй | үгүй | үгүй |
| 13 | Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих төвд тоног төхөөрөмж худалдан авах /Цагааннуур сум/ | 100.0 | үгүй | үгүй | үгүй |
| 14 | Уурын зуухны шинэчлэл 1 тогоо шинээр тавих /Цагаан-Уул сум/ | 130.0 | тийм | үгүй | үгүй |
| 15 | Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн дэргэдэх хуучин уурын зуухны байрын буулгалт /Мөрөн сум/ | 19.0 | үгүй | тийм | үгүй |
| 16 | 72 дугаар эргийн уурын зуухны чулуун барилгын буулгалт /Мөрөн сум/ | 19.0 | үгүй | үгүй | үгүй |
| 17 | 72 дугаар эргийн уурын зуухны  өргөтгөлийн барилгын буулгалт /Мөрөн сум/ | 19.0 | үгүй | үгүй | үгүй |
| 18 | Угтах үдэх хаалга орчмын тохижилтын ажил /Мөрөн сум/ | 150.0 | үгүй | тийм | үгүй |
| 19 | Сумын нэгдсэн халаалтын шугам өргөтгөх /Төмөрбулаг сум/ "Соёлын төвийн дээврийн засвар" болгож өөрчилсөн | 100.0 | үгүй | үгүй | үгүй |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 20 | Сумын төвд нэгдсэн халаалт холбох байгууллагын дотоод сантехникийн их засвар /Эрдэнэбулган сум/ | 100.0 | үгүй | үгүй | үгүй |
| 21 | Инженерийн шугам сүлжээ хийгдсэн гудамжны хотгор гүдгэр хэсгүүдийг шороо асгаж, хусаж, тэгшлэх /Мөрөн сум/ | 50.0 | үгүй | үгүй | үгүй |
| 22 | Цахилгаанаар халаалтаа шийдэх айл өрхүүдийг хөнгөлөлттэй үнээр тарифт тоолуураар хангах | 75.0 | үгүй | үгүй | үгүй |
| 23 | Мөрөн сумын Хогийн цэгийг үе шаттайгаар сайжруулах /Мөрөн сум/ | 400.0 | үгүй | тийм | үгүй |
| 24 | Сумын төвийн хогийн цэгийг булах нүх шуудуу ухах /Арбулаг сум/ | 50.0 | үгүй | үгүй | үгүй |
| 25 | Тусгай зориулалтын машин /Ус, хог/ /Цэцэрлэг сум/ | 80.0 | Тийм | үгүй | үгүй |
| 26 | Хогийн цэгийг дарж булшлах гинжит экскватор худалдан авах /Мөрөн сум/ | 350.0 | үгүй | тийм | үгүй |
| 27 | Цэвэр усны ухаалаг тоолуур худалдан авах /Ус суваг/ | 90.0 | үгүй | үгүй | үгүй |
| 28 | Зөөврийн усан сан барих /Рэнчинлхүмбэ сум/ | 50.0 | Тийм | үгүй | үгүй |
| 29 | Зөв төлөвлөлт-өгөөжтэй эдийн засаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх /санхүүгийн ажилтнуудын тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэх/ Санхүү төрийн сан хэлтэс/ | 45.0 | үгүй | үгүй | үгүй |
| 30 | Аймгийн ИТХ-ын ажлын алба, төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаанд зориулж цахим хурлын тоног төхөөрөмжийг шинэчлэх | 55.0 | үгүй | үгүй | үгүй |
| 31 | Мал эмнэлгийн газрын лабораторийн тоног төхөөрөмжийн шинэчлэл /Мал эмнэлэг/ | 50.0 | Тийм | үгүй | үгүй |
| 32 | Дайвар бүтээгдэхүүн хагас болон бүрэн боловсруулах болон хөргүүрийн тоног төхөөрөмж /Цагаан-Уул сум/ | 50.0 | Тийм | үгүй | үгүй |
| 33 | Хогийн цэг хүртэлх сайжруулсан зам /Мөрөн сум/ | 250.0 | үгүй | үгүй | үгүй |
| 34 | Мөрөн сумын үерийн далан нягтаршуулах, дагтаршуулах, сэргээх ажил эхлүүлэх /Мөрөн сум/ | 250.0 | үгүй | үгүй | үгүй |
| 35 | 10 тн-ын индүү худалдан авах /Улаан-Уул сум/ | 100.0 | үгүй | үгүй | үгүй |
| 36 | Шаардлагатай цэгүүдэд хяналтын камерийн тоог нэмэгдүүлж, шинэчлэх. /Мөрөн сум/ | 150.0 | үгүй | үгүй | үгүй |
| 37 | Багийн төвийг эрчим хүчинд холбох /Бүрэнтогтох сум, Эрчим баг/ | 250.0 | тийм | тийм | үгүй |
| 38 | Сумын төвийн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх /Түнэл сум/ | 50.0 | тийм | үгүй | үгүй |
| 39 | Сумын төвийн 0.4квт-ын шугамын өргөтгөл /Ханх сум/ | 90.0 | үгүй | үгүй | үгүй |
| 40 | Дэрс малчны хороололд цахилгааны трансматер суурилуулах /Тосонцэнгэл сум/ | 60.0 | үгүй | үгүй | үгүй |
| 41 | Соёлын төвийн сандал /Төмөрбулаг сум/ | 10.0 | үгүй | Тийм | үгүй |
| 42 | Шунхлайн уулзварын гэрлэн дохио тавих | 110.0 | үгүй | Тийм | үгүй |
| 43 | Захын хойд уулзварын гэрлэн дохио | 110.0 | үгүй | Тийм | үгүй |
| 44 | ДМЦ сургуулийн урд талын явган гарцын гэрлэн дохио | 60.0 | үгүй | үгүй | үгүй |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **45** | Эрдмийн далай цогцолбор сургуулийн зүүн урд талын явган хүний гарцын гэрлэн дохио | 60.0 | үгүй | үгүй | үгүй |
| **46** | Авьяас сургуулийн урд талын явган хүний гарцын гэрлэн дохио | 60.0 | үгүй | үгүй | үгүй |
| **47** | Гридэр худалдан авах /Жаргалант сум/ | 200.0 | үгүй | үгүй | үгүй |
| **48** | Авто машин худалдан авах /Галт ЭМТ/ | 100.0 | үгүй | үгүй | үгүй |
| **49** | Бохирын шугам худалдан авах /Эрхэс ХҮТ-ын хажуугийнх/ | 50.0 | үгүй | үгүй | үгүй |
| **50** | 6-р багийн ахмадын байр барих /Мөрөн сум/ | 100.0 | үгүй | үгүй | үгүй |
| **51** | 5-р багийн иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийг барих / Мөрөн сум/ | 45.0 | үгүй | үгүй | үгүй |
| **52** | Худаг гаргах /Тариалан сум, ар тархи баг хуурай хөндий/ | 30.0 | үгүй | үгүй | үгүй |
| **53** | Залуучуудын хөгжлийн төвийн засвар /Ногоон заал/ | 150.0 | үгүй | үгүй | үгүй |
| **54** | Хүүхдийн цэцэрлэгийн тохижилт /Баянзүрх сум/ | 20.0 | үгүй | үгүй | үгүй |
| **55** | Эмт багийн төвийн засвар, тохижилт /Баянзүрх сум/ | 20.0 | үгүй | үгүй | үгүй |
| **56** | 640 хүүхдийн сургуулийн дээврийн засвар /Сод-Эрдэм/ | 135.5 | үгүй | Тийм | үгүй |
| **57** | Улс, аймгийн хамгаалалтад авсан түүх соёлын үл хөдлөх дурсгалын кадастрын зураг хийлгэх. /Соёл урлагийн газар/ | 19.5 | үгүй | үгүй | үгүй |
| | **Нийт дүн** | **6,142.0** | | | |

## Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:

<table>
<tr><th>Ирүүлсэн санал:</th><th>Тайлбар:</th></tr>
<tr><td>
МОНГОЛ УЛС<br>ХӨВСГӨЛ АЙМГИЙН<br>ЗАСАГ ДАРГА<br>АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120<br>Утас: 7038 2300, 7038 3303, факс: 7038 1001<br>Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn<br>Цахим хуудас: www.khovsgol.gov.mn<br>2023.11.29 № 1/1932<br>танай ______ -ны № ______ -т<br><br>ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ТАНАА<br><br>Хөвсгөл аймгийн орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргасан гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.<br>Тайлангийн төсөлд тусгагдсан саналаас 500.0 сая төгрөгийн орлого нэмэгдүүлэх, 126.9 сая төгрөгийн зардлыг үр ашигтай төсөл арга хэмжээнд зарцуулах саналуудыг хүлээн авч төсвийн төсөлд тусгахаар шийдвэрлэлээ.<br>Төсвийн төсөлд тусгагдсан 93,6 тэрбум төгрөгийн зардлыг байгууллага болон зардлын зүйлээр ангилсан задаргааг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанд танилцуулах болно.<br>Төсвийн төслийн дүгнэлт гаргах гүйцэтгэлийн аудитын тайлантай холбогдох бусад асуудалд саналыг хүргэв.<br>Хавсралт ..... хуудастай.<br><br>ДАРГА П.ЛХАГВАЖАВ<br>6712030388
</td><td></td></tr>
<tr><td>
Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 1/1932 дугаартай албан бичгийн 2. хавсралт<br><br>ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд дараах зураг төсвийг хүргүүлэх<br>
<table>
<tr><th>№</th><th>Төсвийн дугаар</th><th>Төсөл арга хэмжээний нэр</th><th>Төсөвт өртөг</th><th>2024 онд санхүүжих дүн</th><th>Эхлэх хугацаа</th><th>Дуусах хугацаа</th></tr>
<tr><td>1</td><td>56</td><td>640 хүүхдийн суудалтай сургуулийн дээврийн засвар /Сод –эрдэм/</td><td>135,5</td><td>135,5</td><td>2024</td><td>2025</td></tr>
<tr><td>2</td><td>42, 43, 44,45, 46</td><td>Дугаартай ажлуудын зураг төсөв</td><td>400,0</td><td>400,0</td><td>2024</td><td>2024</td></tr>
</table>
ТАНИЛЦСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА П.ЛХАГВАЖАВ<br>БОЛОВСРУУЛСАН: ХБТХОХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Л.ЗАНДАНМЯДАГСҮРЭН
</td><td>Зураг төсвийг ирүүлсэн 355.5 сая төгрөгийн 3 төсөл араг хэмжээний саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулсан.</td></tr>
</table>

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр
сарын 27-ны өдрийн 1/1934 дугаартай
албан бичгийн 01.. хавсралт

**Хөвсгөл аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдаагүй төсөл, арга хэмжээний жагсаалтаас хасуулах саналтай арга хэмжээнүүд**

| № | Санхүүжилтийн эх үүсвэр | Төсвийн дугаар | Төсөл арга хэмжээний нэр | Хөвсгөл аймгийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө |
|---|---|---|---|---|
| 1 | Их засвар | 2.1.17 | Сумын эрүүл мэндийн төвийн барилгын засвар /Эрдэнэбулган сум/ | 1.5.1.18-д ерөнхий нэршлээр орсон. |
| 2 | | 2.1.18 | 150 хүүхдийн дотуур байрны гал тогооны засвар /Баянзүрх сум/ | 1.1.1.9-д ерөнхий нэршлээр орсон. |
| 3 | | 2.1.19 | 150 хүүхдийн дотуур байрны өрөөний засвар /Баянзүрх сум/ | 1.1.1.9-д ерөнхий нэршлээр орсон. |
| 4 | | 2.1.20 | Дээд модот буланд Эрүүл мэндийн цэгийн засвар /Хатгал/ | 1.5.1.18-д ерөнхий нэршлээр орсон. |
| 5 | | 2.1.21 | Хүүхдийн цэцэрлэгийн дээврийн засвар /Шинэ-Идэр сум/ | 1.1.1.9-д ерөнхий нэршлээр орсон. |
| 6 | | 2.1.22 | Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн хөлбөмбөгийн талбайн засвар | 1.1.1.9-д ерөнхий нэршлээр орсон. |
| 7 | | 2.1.23 | Дотуур байрны засвар /Чандмань-Өндөр сум/ | 1.1.1.9-д ерөнхий нэршлээр орсон. |
| 8 | | 2.1.24 | Хүүхдийн цэцэрлэгийн дээврийн их засвар /Мөрөн сум 8-р баг/ | 1.1.1.9-д ерөнхий нэршлээр орсон. |
| 9 | ОНТХО | 2.1.2 | Автомашин худалдан авах /ЗДТГ/ | Тусгагдаагүй |
| 10 | Замын сан | 2.1.10 | Ирээдүй сургууль хүртэл зам тавих 300 метр | 11.9.1.1-д ерөнхий нэршлээр орсон. |
| 11 | | 2.1.11 | Чигжийн голын гүүр барих /Бүрэнтогтох сум, Урандөш зуслан/ | 11.9.1.1-д ерөнхий нэршлээр орсон. |
| 12 | | 2.1.15 | Онцгой байдлын газар хүртлэх зам тавих 250 метр | 11.9.1.1-д ерөнхий нэршлээр орсон. |

**Зураг, төсөвгүй төсөл арга хэмжээний жагсаалтаас дараах төсөл арга хэмжээнүүдийг хасуулах саналтай**

| № | Төсвийн дугаар | Төсөл арга хэмжээний нэр | Төсөвт өртөг | 2024 онд санхүүжих дүн | Эхлэх хугацаа | Дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2.1.4 | Хүүхдийн цэцэрлэгийн засвар /Могойн гол баг/ | 73,0 | 73.0 | 2024 | 2024 |
| 2 | 2.1.5 | ЕБС-ийн хичээлийн байрны их засварын дутуу санхүүжилт /Рашаант сум/ | 75,0 | 75,0 | 2024 | 2024 |
| 3 | 2.1.6 | Аймгийн нэгдсэн эмнэлэгийн дээврийн их засвар | 186,4 | 186,4 | 2024 | 2024 |
| 4 | 2.1.7 | Аймгийн нэгдсэн эмнэлэгийн угаалгын байрны их засвар | 117,8 | 117,8 | 2024 | 2024 |
| 5 | 2.1.9 | Музей, номын сангийн байрны сантехникийн их засвар | 200,0 | 200,0 | 2024 | 2024 |
| 6 | 2.1.22 | Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн хөл бөмбөгийн талбайн засвар. | 216,8 | 120,0 | 2024 | 2024 |

ТАНИЛЦСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА П.ЛХАГВАЖАВ
БОЛОВСРУУЛСАН: ХБТХОХ-ИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН Л.ЗАНДАНМЯДАГСҮРЭН

*Ирүүлсэн саналаас 3,519.8 сая төгрөгийн 8 арга хэмжээний саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулсан*

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр
сарын 27-ны өдрийн 1/1934 дугаартай
албан бичгийн 3... хавсралт

**ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад иргэдийн саналыг аваагүй гэсэн жагсаалтаас дараах арга хэмжээнүүдийг хасуулах саналтай**

| № | Төсөл арга хэмжээний нэр | Эрэмбэ, оноо |
|---|---|---|
| 1 | Цэцэрлэгийн тоглоомын талбайн тохижилтыг нэмэгдүүлэх /Мөрөн сум 15 цэцэрлэгт/ | 26 |
| 2 | "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг хэрэгжүүлэх | 20 |
| 3 | "Амгалан амьдрал"арга хэмжээний хүрээнд архины хамааралтай иргэдийг эмчлэн эрүүлжүүлэх, сургалт сурталчилгаанд хамруулах | 23 |
| 4 | Эрт илрүүлэг үзлэгт иргэдийг үе шаттайгаар хамруулах ажлын хүрээнд зөөврийн эхо аппарат худалдан авах /Нэгдсэн эмнэлэг/ | 24 |
| 5 | "Эрүүл шүд Эрүүл ахуй" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 24 |
| 6 | Мөрөн сумын "Хиймoрийн овооны тохижилтын ажил эхлүүлэх" /Мөрөн сум/ | 19 |
| 7 | Техник хэрэгсэл /Цагдаагийн газар/ | 21 |
| 43 | Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих тэвд тоног төхөөрөмж худалдан авах /Цагааннуур сум/ | 30 |
| 47 | Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн дэргэдэх хуучин уурын зуухны байр, 72 дугаар иргийн уурын зуухны чулуун барилга, өргөтгөлийн хамт буулгах ажлын төсөв | 23 |
| 48 | Мөрөн сумын угтах үдэх хаалга орчмын тохижилтын ажил /Мөрөн сум/ | 8 |
| 49 | Сумын нэгдсэн халаалтын шугам өргөтгөх /Төмөрбулаг сум/ | 24 |
| 50 | Сумын төвд нэгдсэн халаалт холбох байгууллагын дотоод сантехникийн их засвар /Эрдэнэбулган сум/ | 29 |
| 51 | Инженерийн шугам сүлжээ хийгдсэн гудамжны хоттор гүдгэр хэсгүүдийг шороо асгаж, хусаж, тэгшлэх /Мөрөн сум/ | 22 |
| 6 | Цахилгаанаар халаалтаа шийдэх айл өрхүүдийг хөнгөлөлттэй үнээр тарифт тоолуураар хангах | 34 |
| 54 | Мөрөн сумын Хогийн цэгийг үе шаттайгаар сайжруулах /Мөрөн сум/ | 29 |
| 55 | Сумын төвийн хогийн цэгийг булах нүх шуудуу ухах /Арбулаг сум/ | 29 |
| 56 | Тусгай зориулалтын машин /Ус, хог/ /Цэцэрлэг сум/ | 27 |
| 57 | Хогийн цэгийг дарж булшлах гинжит экскаватор худалдан авах /Мөрөн сум/ | 25 |
| 84 | Цэвэр усны ухаалаг тоолуур худалдан авах /Ус суваг/ | 30 |
| 63 | Зөв төлөвлөлт-өгөөжтэй эдийн засаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх /санхүүгийн ажилтнуудын тоног төхөөрөмжийг үе шаттай шинэчлэх/ Санхүү төрийн сан хэлтэс/ | 29 |
| 9 | Аймгийн ИТХ-ын ажлын алба, төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаанд зориулж цахим хурлын тоног төхөөрөмжийг шинэчлэх | 20 |
| 64 | Мал эмнэлгийн газрын лабораторийн тоног төхөөрөмжийн шинэчлэл /Мал эмнэлэг/ | 24 |
| 67 | Хогийн цэг хүртэлх сайжруулсан зам /Мөрөн сум/ | 24 |
| 68 | Мөрөн сумын үерийн далан нягтаршуулах, дагдаршуулах, сэргээх ажил эхлүүлэх /Мөрөн сум/ | 29 |
| 69 | Сумын төвийн хайрган хучилттай 3.5 км авто зам барих /Алаг-Эрдэнэ сум/ | 26 |
| 10 | Шаардлагатай цэгүүдэд хяналтын камерийн тоог нэмэгдүүлж, шинэчлэх. /Мөрөн сум/ | 25 |
| 78 | Сумын төвийн 0.4квт-ын шугмын өргөтгөл /Ханх сум/ | 21 |

ТАНИЛЦСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА П.ЛХАГВАЖАВ
БОЛОВСРУУЛСАН: ХБТХОХ-ИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН Л.ЗАНДАНМЯДАГСҮРЭН

*Ирүүлсэн саналаас*

*- Тусгай зориулалтын машин /Ус, хог/ /Цэцэрлэг сум/ 80.0 сая төгрөг*

*-Мал эмнэлгийн газрын лабораторийн тоног төхөөрөмжийн шинэчлэл 50.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээний саналыг хүлээн авч тайланд өөрчлөлт оруулсан.*